

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯМАНД


Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд:

“ХХ.9. “Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумьяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. БНЭУ-ын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай)-ыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан, явц, үр дүнгийн талаар танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноров нарт тус тус даалгав.

2. Засгийн газрын тухай хуулийн 20.5.12-т заасан эрхэлсэн асуудлын хүрээний дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, бодлогын болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумьяабазарт үүрэг болгов.

3. Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д олгох зээлийн санхүүжилтийг ирээдүйд бий болох хөрөнгөөр барьцаалах замаар олгох асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумьяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Хөгжлийн банкны гүйцэтгэх Б.Батбаяр нарт даалгав.”” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР